



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/187

Чойр

Отор нүүдлийн шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлаж хяналт тавих тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтанд авах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчин бүртгэгдсэн аймаг, сумаас орох малын шилжилт хөдөлгөөнийг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хязгаарласугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үеийн мал эмнэлгийн бэлэн байдлыг хангах, тандалт судалгаа хийх, отор нүүдлийн шилжилт хөдөлгөөний хяналтыг эрчимжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Ч.Отгонсүрэн)-д, Отор нүүдлийн шилжилт хөдөлгөөний хязгаарлалтыг сахиулан хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэлтсийн дарга (Ц.Баярхүү)-д, Онцгой байдлын газрын дарга (Х.Сүхбаатар)-д, Малын гоц халдварт өвчний талаарх мэдээлэл, эрт сэрэмжлүүлгийг иргэд, малчдад хүргэх, ухуулан таниулах, сумын нутаг дэвсгэрт орж ирсэн отор, нүүдлийг холбогдох байгууллагад шуурхай мэдээлж, хамтарч ажиллахыг Сүмбэр сумын Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ)-д, Баянтал сумын Засаг дарга (Б.Ганбаяр)-д, Шивээговь сумын Засаг дарга (Ч.Сугармаа)-д, ХХААГ-ын дарга (Э.Түвшинзаяа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Хонгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4218400181

10/10